



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 4/513

Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасгийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Ганхуяг (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Ж.Бодьгэрэл (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Г.Ууганбаатар (Хөндлөнгийн төлөөлөл)
(тохиролцсон)

Б.Галсанжамц (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Анхбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Ганхуяг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ